



“ДАРХАН ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР”  
ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ П.ЭРДЭНЭЦОГТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-08 № 2/50


Г Ханшийн тэгшитгэл хийх тухай

“Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар гадаад валютын үлдэгдэлд 4 332.5 сая төгрөгийг хаалтын ханшаар бүртгэж тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 9.3 дахь хэсэгт зааснаар “Санхүүгийн тайлан гаргахдаа гадаад валют, түүгээр илэрхийлсэн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлж бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх....”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.Үүнд:

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг гарган 2013 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн захирал П.Эрдэнэцогт, Ерөнхий нягтлан бодогч Д.Даваадорж нарт хариуцуулав.



0751-3